

**Сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалууд
монгол хэлний түүхэн хөгжлийн баримт болох нь**

Д.Заяабаатар¹

XIII-XVI зуун буюу сонгодог бичгийн өмнөх үеийн монгол бичгийн дурсгалд тухайн цагийн ярианы хэлний нөлөө тусгал ямар янзаар илрэх, угтаа дундад үеийн монгол хэлний төлөв байдал бичгийн хэлэнд яаж нөлөөлөв, нөгөө талаар эртний монгол хэлний үлдэл хоцрол, ул мөр хэрхэн хадгалагдаж ирэв гэдгийг тодруулах нь хэлний түүхэн хөгжлийн судалгаанд багагүй тус нэмэртэй юм. Хэдийгээр дөрвөлжин, араб, хятад үсгээр уламжлан ирсэн дурсгалын зүйл шиг бүхэлдээ дундад үеийн монгол хэлний эш баримт болохгүй ч нэгэнт хэвшсэн зүй тогтолтой монгол бичгийн хэлэнд нөлөөлж, эрт түрүү цагийн ул мөрөө үлдээсэн онцлог нь хэлний түүхэн хөгжлийн судалгаанд ихээхэн үнэ цэнтэй, сонин баримт болох учиртай. Бид, дурдан буй үеийн монгол бичгийн дурсгал нь анх үүсэн бүрэлдсэн цагийнхаа (эртний монгол хэл Д.3) хэлний төлөв байдлын үлдэл хоцролыг зохих хэмжээгээр тээн хадгалахын зэрэгцээ туулж ирсэн үеийнхээ (дундад үеийн монгол хэл Д.3) хэл аялгууны онцлог шинжээс тусгал авсан байх ёстой гэсэн үзэл хандлагаар чиг баримжаа хийж байгаа билээ.

Гэвч олны мэдэхээр, монгол бичгийн ирэл үүдлийн эх цэг нь тус бичгээр уламжлан ирсэн бодот дурсгалын хамаатах цагаас хавьгүй өмнө, XIII зуунаас хол эрт үед онолдох бүрэн боломж бий. Бидэнд мэдэгдэж байгаа сурвалж баримтын хэлний төлөв байдал, зөв бичих зүйн онцлогоос үзвэл, дундад үеийн монгол хэлний тэргүүн хагас гэхэд монгол бичиг хэдийнээ хэвшин тогтсон хэвшинжийг олсон байжээ гэж хэлэх үндэстэй. Өөрөөр хэлбэл, дурдан буй үеийн бичгийн дурсгалд тохиолдох үгсийн бүтэц, хэлзүйн хэлбэржилтийг өнөөгийн монгол бичгийн төлөв байдалтай харьцуулахад хэлбэрийн талаас зөрөө гарахаас бус тэдгээрийн зөв бичих ерөнхий зарчимд ноцтой харшлах зүйл тун цөөн гэж хэлж болно. Харин цөөн боловч тохиолдож буй тэдгээр зөрөөтэй асуудал л зайлшгүй анхаарлаа хандуулах баримт мөн.

Бидний учрыг тодруулах гэж мөшгөж буй баримт жишээ нь нэгэн хоёроор хязгаарлагдахгүй болохоор алдаа эндэл гээд хэлчихэд эрхбиш эргэлзээ төрмөөр байгааг дурдвал зохино.

XIII-XVI зууны монгол бичгийн дурсгалын зүйлийг нягтлан үзсэний үндсэнд аман ярианы нөлөө тусгал гэж баталж болохуйц онцлог тохиолыг энд авч үзнэ. Түүнээс улбаалж, монгол хэлний авианы түүхэн хувьслын талаар ямар санал дүгнэлт хэлж болохыг урьд өмнө судалсан эрдэмтдийн ном бүтээл, өөрийн ажигласан баримт хэрэглэхүүнд тулгуурлан гаргахыг хичээв.

Монгол хэлний түүхэн хөгжлийг судлан шинжилсэн эрдэмтэд дундад үеийн монгол хэл аялгууны онцлогийг шууд тусган тэмдэглэсэн үлэмжхэн дурсгалд тулгуурлаж, тэр цагийн хэлний төлөв байдлыг нэгэнтээ тодорхойлсон нь бидний ажилд чухал суурь болж байна. Үүний үндсэн

¹ МУИС-ийн багш / БНСУ-ын Дангүг (Dankook) их сургуулийн урилгын багш.

дээр, монгол бичгийн зөв бичих зүйн тулгуур зарчим, гол тогтолцоогоор шалгуур хийж, аман ярианы нөлөө тусгалаас үүдэлтэй тэрхүү онцлог тохиолууд хэлний түүхэн хөгжилд ямар эш баримт болохыг нутлан тайлбарлана.

Тэмдэглэх нэгэн зүйл, дундад үеийн монгол хэлний дурсгалын судлалаар гарсан ном зохиол олон боловч бид өөрсдийн ажилд эш баримт татахдаа хамгийн сүүл үед гарсан эхийн галиг, бүх үгийн хэлхээтэй бүтээлүүдийг² тулгуур хэрэглэхүүн болгон ашиглав.

Ингээд өгүүлэн буй асуудлыг улируулан шинжлэхийн учирт дараах хэдэн онцлогт дулдуйдан тайлбарлаж, өөрийн санал дүгнэлтээ танилцуулъя.

1. Гийгүүлэгчийн сугарал

Гийгүүлэгчийн сугарлын тухай асуудал нь угтаа монгол хэлний урт, хос эгшгийн улирал хөгжилтэй нягт холбогдох зүйл билээ.

Монгол бичгийн дурсгалын зүйлд гийгүүлэгчийн сугарлыг хэрхэн тусгасан болохыг хянан нягталж, шүүрдэн үзэхэд дараах жишээ баримт таарч байна. Үүнд:

<i>yadā</i> < * <i>yadayā</i>	[Čang:15], [Sulqarnai:11a12]
<i>uqātu</i> ³ < * <i>uqayātu</i>	[Turfan/Kümün:15b04]
<i>čayān</i> < * <i>čayayān</i>	[Jebetemür:11], [Subasida:V-9a], [Arjai09:02],
<i>jayāyda-</i> < * <i>jayayāyda-</i>	[Sulqarnai:11a01]
<i>maytāl</i> < * <i>maytayāl</i>	[Maytayal:23-01], [Dara/Tegüsgel:01b07]
<i>urūl</i> < * <i>uruyūl</i>	[Subasida:III-12a]
<i>qayūčid-ta</i> ⁴ < * <i>qayūčid</i>	[Busayid1325:22-23], [Nur Ad-Din:01-02]
<i>burūsiyabasu</i> < * <i>buruyūsiyabasu</i>	[Takimdayu24a02]
<i>yabūlbasu</i> ⁵ < * <i>yabuyūlbasu</i>	[TurfanTQ:11]
<i>tūrbiju</i> < * <i>tuyūrbi-</i>	[Gasan:06]
<i>dolōn</i> ⁶ < * <i>doloyān</i>	[Qaraqota07-08]
<i>oyōr-</i> < * <i>oyayara-</i>	[Burqan:25a; 41b; 44b, 57b; 61a]
<i>ilē-</i> < * <i>ilegē-</i>	[Möngke1254:03], [Aryun1289:31], [Gasan:03; 06],
	[Čang:32], [Öljeyitü:35], [Qaraqorum1346:08]
<i>ibēgde-</i> < * <i>ibegēgde-</i>	[Öljeyitü:27]
<i>inēgül-</i> < * <i>inegēgül-</i>	[Subasida:III-4b]
<i>öčūken</i> < * <i>öčügūken</i>	[Jigüntei:32; 33], [Čang:41], Takimdayu:18a03],
	[Subasida:II-4a; III-4b; III-11a]
<i>öčūked</i> < * <i>öčügūked</i>	[Indü:28], [Takimdayu:32a04]
<i>türün</i> < * <i>terigün</i>	[Takimdayu:02b06]
<i>narin</i> < * <i>narigin</i>	[Turfan/Tamu:12, 27], [Subasida:V-3b]

² I.de.Rachewiltz, *Index to the secret history of the mongols*, Bloomington, 1972, 343 p; *Word and Suffix-Index to the Secret History of the Mongols* based on the Romanized Transcription of L.Ligeti, Compiled by H.Kuribayashi & Choijinjab, The Center for Northeast Asian Studies, Tohoku University, Sendai, 2001, 953 p; Д.Төмөртоогоо, *Араб үсгийн монгол дурисхалын судалгаа*, Улаанбаатар, 2002, 172 тал; Д.Төмөртоогоо, *Дөрвөлжин үсгийн монгол дурисхалын судалгаа*, Улаанбаатар, 2002, 182 тал; Ё.Жанчив, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал*, Улаанбаатар, 2002, 195 тал; *Word and Suffix-Index to Hua-yi Yi yü* based on the Romanized Transcription of L.Ligeti, Compiled Hitoshi Kuribayashi, The Center for Northeast Asian studies, Tohoku University, Sendai, 2003, 177 p.

³ Н.Поппе үүнийг *uqa-* үйл язгуурт *-n*, *-yan* хоёр зүйлийн дагавар залгаснаас үүдэлтэй гэж тайлбарлажээ. Үз: Nikolaus Poppe, *Ein Mongolisches Gedicht aus den Turfan-Funden*, CAJ:5 (4), p. 285.

⁴ G.Herrmann und G.Doerfer, *Ein persisch-mongolischer erlass aus dem Jahr 725/1325*, ZDMG:125, p. 342.

⁵ D.Cerensodnom M.Taube, *Die Mongolica der Berliner Turfansammlung*, Berlin, 1993, p. 186.

⁶ F.W.Cleaves, *An early Mongolian loan contract from Qara qoto*, HJAS:18, 1955, p 5.

Энэ мэт тохиолдол яах аргагүй гийгүүлэгчийн сугарлыг шууд тусган тэмдэглэсэн хэрэг мөн. Зөвхөн гийгүүлэгчийн сугарлыг тусгаад зогсохгүй $V\gamma/gV$ цогц дахь сугарсан гийгүүлэгчийн өмнөх эгшгийн гээгдлийг давхар илтгэж, улмаар ярианд нэгэнтээ хэвшин дуудагдах болсон урт эгшгийн төлөв байдлыг заан илрүүлсэн нь эргэлзээгүй юм. Бид дээрх зүй тогтлыг санамсаргүй тохиол гэж үзэхээс илүү үүсмэл урт эгшгийн гарал ирэлтэй холбогдох сонирхолтой баримт хэмээн сэтгэж, дараах таамгийг дэвшүүлж байна.

Монгол хэлний үүсмэл урт эгшиг хэвшин тогтох эх үүдэл нь нэрт монголч, алтайч эрдэмтэн Ш.Хаттори, Н.Поппе, академич Ш.Лувсанвандан нарын үзсэнчлэн⁷, хоёр эгшгийн хоорондох γ, g гийгүүлэгч арынхаа өргөлтөөс (академич Ш.Лувсанвандан абугайн үзсэнээр "утга ялгах өргөлт" Д.З) эхтэй урт эгшгийн нөлөөгөөр сулран сугарсан явдал юм.

Тэгвэл, тус гийгүүлэгчийн өмнө байсан эгшиг ямар авианы хувьслаар сугаран гээгдсэн бэ гэдэг асуулт зүй ёсоор гарна. Хэдий балархай байсан ч болов шууд гээгдсэн гэж үзэхэд эргэлзээтэй. Бидний санахад, гийгүүлэгчийн сугарлын дараа үүсмэл урт эгшиг нь өмнөх балархай эгшгээ ижилшүүлэх авианы хувьсал явагдсан байх ёстой. Харин тэрхүү богино эгшиг нь үүсмэл урт эгшигтэйгээ ижил авиа байсан тохиолдолд сугарах хувьсалд саад бэрхшээл төдийлөн гарахгүй нь тодорхой. Харин уг богино эгшиг үүсмэл урт эгшгээсээ өөр авиа байсан бол зайлшгүй ухран ижилших хувьслыг туулсны дүнд сугаран гээгдэх ёстой гэж үзэж байна. Үүнийг жишээгээр загварчлан үзүүлбэл:

PM **dayūn* > AM *dayūn* > MM *dawūn* > *da'ūn* > (*do'un*) *du'ūn* > *dū*
PM **qayān* > AM *qayān* > MM *qahān* > *qa'ān* > > *qān*

Эрдэмтэн Гарьд "Дундад эртний монгол хэлний судлал" хэмээх бүтээлдээ "...уртатгал бүтэц дэх γ, g, y зэрэг гийгүүлэгч авианы өмнөх тэр эгшиг, урт эгшгийн буй болох явцад хэдийгээр богино эгшиг авиа байсан боловч гээгдээгүй, харин хоёр эгшгийн дундах гийгүүлэгчийн баларч гээгдсэний сүүлээр нэг цаг хугацаанд биеэ даасан үе байснаа дараагаар зарим нь хойнох эгшигтэйгээ нийлээд хос эгшиг болж хувираад хожим нь урт эгшиг болсон, хэрэв өмнөх хойнох эгшиг нь адил байсан байвал биеэ дааж байсан үеэсээ шууд урт эгшиг болсон байна"⁸ гэж тэмдэглэсэн байна.

Өмнө өгүүлсэн дүгнэлтээс ургуулан бодохул, *эгшиг+γ/g+эгшиг* цогцоос үүсмэл урт эгшиг хэвшин тогтсон авианы түүхэн хувьсал нь дараах хэдэн үе шатыг туулсан байна.

- 1) Угаас утга ялгах өргөлттэй байсан эгшиг нь хэлний түүхэн хөгжлийн явцад урт эгшгийн шинж төлөвийг олсон.
- 2) Үүсмэл урт эгшгийн нөлөөгөөр өмнөх g, γ гийгүүлэгч нь суларч, сул шүргэх h, w, y болсон.
- 3) Хоёр эгшгийн хоорондох шүргэх гийгүүлэгч сулран суларсаар, аажимдаа сугаран гээгдсэн.
- 4) Сул шүргэх гийгүүлэгчийн өмнө байсан богино эгшиг нь арын урт эгшигтэйгээ ухран ижилшсэн.
 - 4а. Хэрэв богино эгшиг үүсмэл урт эгшигтэйгээ ижил байвал авианы нөлөөтөх хувьсал (ижилшил Д.З) явагдахад тодорхой хугацаа шаардахгүй.
 - 4б. Хэрэв богино эгшиг үүсмэл урт эгшгээсээ өөр бол авианы нөлөөтөх хувьсал (ижилшил Д.З) явагдахад тодорхой хугацаа шаардаж таарна.
- 5) Богино эгшиг нь арынхаа урт эгшигт бүрэн ижилшсэний дараа авианы байрын талаас ямар ч үүрэггүй болж, мөн сугаран гээгдсэн.

⁷ Sh.Hattori, *The length of vowels in Proto Mongolian*, MS, Budapest, 1970, pp. 186-194; N.Poppe, *The primary long vowels in Mongolian*, JSFO:63 (2), Helsinki, 1962, pp. 1-19; Ш.Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудал*, ХЗС:4, Улаанбаатар, 1966, 5-26.

⁸ Garudi, *Dumdadu erten-ü mongyol kelen-ü sudulul*, Liyuuning, 2001, 172-р тал.

Нэрт монголч эрдэмтэн Г.Д.Санжеев "Ялангуяа ижил эгшгээс бүтсэн хоёр үе (жишээлбэл, $a+a$, $i+i$, $e+e$) нь маш богино хугацаанд нийлж, одоогийн урт эгшгийн (\bar{a} , \bar{i} , \bar{e}) төлөвийг олжээ. Харин хоёр өөр эгшгээс (жишээлбэл, $o+a$, $a+y$, $e+y$) бүтсэн үе нь могол, дагур хэлэнд тохиолддог шиг нэлээд удаан хугацаанд хос эгшгийн байдалтай байсаар байжээ"⁹ гэсэн нь урт эгшгийн бүрэлдсэн явцад үл нийцэх дүгнэлт боловч энэхүү авианы хувьсалд оролцох богино эгшгийн оролцоог зөв тодорхойлсноороо ихээхэн ач тустай юм. Таамгаар хэлэхэд, гийгүүлэгчийн хоёр талын эгшиг нь ижил байсан цогцоос бүрэлдсэн үүсмэл урт эгшгийн хамаатах цаг нь эртний монгол хэлний сүүл үед онолдох бол хоёр өөр эгшиг бүхий цогцоос улирсан үүсмэл урт эгшиг нь түүнээс арай хожуу буюу илүү хугацаа шаардсаны дараа, барагцаалбал дундад үеийн монгол хэлний эхэн орчимд бий болсон үр дүн бололтой. Тийм учраас, монгол бичгийн зөв бичих зүйн тогтолцооны үүднээс *buruyusiyabasu*, *yabuyulbasu*, *yaday_a*, *uqayatu*, *ilege-*, *ibege-*, *inegegül-*, *čayayan*, *öčügüken*, *öčügüked*, *türügün* гэж буулгах ёстой үгсийг *burüsiyabasu*, *yabülbasu*, *yadā*, *uqātu*, *ilē-*, *ibē-*, *inēgül-*, *čayān*, *öcüken*, *öcüked*, *türün* гэж аман ярианд хэвшин тогтоод байсан урт эгшгийн төлөв байдлыг шууд тусган тэмдэглэсэн хэрэг. Мэдээжийн хэрэг, өмнөх үгсийг зөв бичих зүйн тулгуур зарчмын дагуу буулгасан жишээ монгол бичгийн дурсгалаас хялбар олдох билээ. Бас ярианы хэлэнд нэгэнт уртаар дуудах болсныг шууд тусгах замаар давхар эгшгээр уртатгалыг тэмдэглэсэн тохиолдол харьцангуй цөөн ч *idekü uuqu bolbasu* [Subasida:III-4b], *idekü-dür uuqui-dür kürbesü sinuyu* [Subasida:III-11b] гэсэн жишээ таарч буйг дурдах нь зүйтэй.

Харин хоёр өөр эгшгийн дундах гийгүүлэгч бүхий нийлэмжийн богино эгшиг нь арынхаа урт эгшигтэй хараахан ижилшээгүй байсан болохоор *qaučid* хэмээн тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, монгол хэлний урт эгшиг бүрэлдэн тогтох явц дахь авианы хувьслын нэгэн үе шатыг шууд тусгасан хэрэг юм. Ийм жишээ *qaučid* гэснээс өөр олдохгүй байгаа нь санамсаргүй зүйл биш угтаа хоёр өөр эгшгийн дундах гийгүүлэгчийн сугарал, ижил эгшиг бүхий цогцоос арай удаан явагдсаныг илтгэх баримт гэж үзэлтэй.

Дээрх онцлогуудад тулгуурлаж, дурдууштай нэгэн зүйл бол, *keiken*, *taulai*, *teike* гэх онцгой бичлэгтэй үгс нь хоёр өөр эгшгийн хоорондох гийгүүлэгчийн сугарлыг шууд тусган тэмдэглэснээс эх үүдэлтэй, улмаар монгол бичгийн зөв бичих зүйд хэвшин тогтсон хэлбэр байхыг үгүйсгэх аргагүй. Ингэж үзэх нь зохистойг судалгаандаа дурдсан эрдэмтэд бий¹⁰. Б.Я.Владимирцов¹¹ эдгээрийн хувьслыг $*aw > au > \bar{u}$, $*ow > ou > \bar{o}$, $*ew > eü > \bar{ü}$ гэж тодорхойлохын хамт төрөл хэлний баримттай харшуулан тайлбарласан билээ. Энэхүү w дэвсгэр гийгүүлэгч нь монгол хэл болоод монгол бичгийн хөгжлийн эрт үед байсан эсэх асуудлыг эргэн нягтлах ёстой.

Харамсалтай нь, монгол бичгийн дурсгалаас баримт болгоод хэлчих зүйл олсонгүй. Харин "Монголын Нууц Товчоон"-д *kö'üken* [§114; §135; §137; §138; §214], *kö'üked* [§78], *taulai* [§257], *ta'ulai* [§239], "Hua-yi Yi-yü" тольд *keiken* [1:15b2], *kö'üket* [3:18a3; 3:18a4], *taulai* [1:06a2], араб үсгийн дурсгалд *ta'ulai* [Д.Төмөртоогоо:143], *ke'üken* [Д.Төмөртоогоо:77] гэсэн хэлбэрээр тохиолдож байгааг анхаарвал зохино. Үүнээс үндэслэж, эдгээр үгийн авианы хувьслыг доорх байдлаар сэргээн гаргаж болох юм.

$*kegüken > *kegüken > kewüken > ke'üken > kö'üken > kü'üken > kügen$
 $*tayülai > *tayülai > tawülai > ta'ülai > to'ülai > tu'ülai > tülai$

Үүнтэй холбогдох бас нэг баримт бол зарим төрөл хэлэнд хоёр талдаа ижил эгшиг бүхий цогцын байранд үүсмэл урт эгшиг орчин цагийн монгол хэлний шинжээр хадгалагдан үлдсэн байхад өөр эгшиг бүхий цогцын байранд гийгүүлэгч нь сугарсан боловч эгшгүүд ижилшиж

⁹ Г.Д.Санжеев, *Сравнительная грамматика монгольских языков*, Том I, Москва, 1953, стр. 78.

¹⁰ М.Базаррагчаа, Ч.Жачин, *Уйгуржин монгол бичиг урт, хос эгшигийг тэмдэглэсэн нь*, "Монгол хэлний авианы чөлөөт сэлгэцийн тухай", Улаанбаатар, 1992, 114; Garudi, *Dumdadu erten-ü mongyol kelen-ü sudulul*, Ljyuuning, 2001, 170-р тал.

¹¹ Б.Я.Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Москва, 1989, 255-257.

амжаагүй байдлаар хэвшин тогтсон явдал юм¹²

Ямар боловч, *эгшиг+гийгүүлэгч+эгшиг* цогцын түүхэн хөгжлийн үе шатыг ярихад нэг талаас эгшгүүдийн ижил болоод өөр эсэх, нөгөөтээгүүр тэрхүү нийлэмж дэх гийгүүлэгчийн өмнөх богино эгшгийн онцлог шинжийг анхаарч, үүсмэл урт эгшгийн хэвшин тогтсон хугацаа хийгээд дамжин туулсан авианы хувьслыг салган хэлэлцэх шаардлагатай гэж бодож байна.

Дундад үеийн монгол хэлний төлөв байдлыг илтгэх бодот дурсгалуудад урт эгшгийн хувьсал хөгжлийг хэрхэн тэмдэглэснийг хянан үзэхэд, араб үсгийн баримт хэрэглэхүүнд сонин тохиолдол¹³ ажиглагдаж байна. Тэнд *adu'u:n, adu'u:nči, adu'u:sun, buda'a:n, čaqa'a:n, če'e:ji* гэх зэргээр дундад үеийн монгол хэлний авианы үндсэн хувьслыг тэмдэглэхийн сацуу *adu:n, adu:sun, amu:l-, arču:r, bo:l, buru:, buda:n, čaqa:n, če:ji (=če:jin)* гэж урт эгшгийн төлөвийг олсон хэлбэрийг шууд тусган буулгасан байгаа нь бидний хэлээд байгаа таамаг дүгнэлтийг үнэнд ойртуулах нэг нуталгаа болно. Тэр ч байтугай, *bo'ol > bo'ol > bo:l, čö'en > čö'on > čö:n, ebčewü:n > ebče'ü:n > ebčü'ü:n > ebčü:n* гэх мэтээр үүсмэл урт эгшиг өнөөгийн хэвшинжийг олох хүртэлх хувьслын үе шатуудыг тусган тэмдэглэсэн нь ихээхэн сонирхолтой ажээ. Н.Н.Поппе¹⁴ "*Мукаддимат Ал-адаб*" толийн авиазүй, үгзүйн онцлогийг шинжлэхдээ дээрх жишээнд хамаатах үгсийг бүлэглэн жагсаасан байдгийг дурдах нь зүйтэй.

Бас нэгэн зүйл, дээр жишээ татсантай ижил хувьслыг туулсан зарим үг гийгүүлэгчийн сугарлыг тусган тэмдэглэсэн байдлаараа орчин цагийн монгол бичгийн зөв бичих зүйд хэвшин тогтсон байдаг. Тухайлбал: *gegen* *ᠭᠡᠭᠡᠩ*, *andayār* *ᠠᠨᠳᠠᠶᠠᠷ*, *čayān* *ᠴᠠᠶᠠᠨ*, *öčüken* *ᠥᠴᠦᠬᠡᠨ*, *ury-a* *ᠤᠷᠦᠶᠠ* гэх мэт. Ийм үгсийг сүүлийн үед гарсан монгол бичгийн сурах бичиг, зөв бичих зүйн холбогдолтой ном товхимолд "*богиноор бичиж, уртаар дууддаг үг*" хэмээн нэрийдэж тайлбарласан харагддаг. Угтаа энэ мэт бичлэгийн цаад учир бол, хоёр ижил эгшгийн дундах гийгүүлэгч (*g/y* Д.3) арынхаа утга ялгах өргөлтөөс эхтэй урт эгшгийн нөлөөгөөр сугарч, улмаар мөнхүү *VgV, VγV* цогцын байранд өнөөгийн урт эгшиг дуудагдах болсон үеийн онцлогийг шууд тусган тэмдэглэснээс эх үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, монгол хэлний түүхэн хөгжлийн явцад гарсан авианы нэгэн зүйл хувьслаас монгол бичгийн зөв бичих зүйд тусгал болон үлдэж, хэвшин тогтсон хэлбэр гэж үзвэл зохино. Эдгээр үгийн өмнөх хэлбэрийг сэргээвэл:

- **andayāyar* > *andayār* *andayāyar metü sedkijü* [Öljeiti:18]
**čayāyan* > *čayān* *čayāyan* [Burqan:57b], [BčaT:167b07]
 čayāyād [Sulqarnai:13a08]
**öčügüken* > *öčüken* *öčügüken* [Indü:26; 46], [BčaT:156a04;
 163a03], [Burqan:14a; 40a, 63a]
**gegegēn* > *gegēn* [Jigüntei:30]

болно.

Түүнчлэн, монгол бичгийн зөв бичих зүйн тогтолцоонд давхар эгшгээр уртатгалыг (*au, uu, eü, iü, oo, ii, iü, iu* цогц Д.3) тэмдэглэх бас нэгэн арга буй бөгөөд тийнхүү "журамлан хэвшүүлэх болсны хөрс суурь нь одоо үеийн урт эгшиг үүссэн цагаас бүрэлдэн тогтсон гэж үзэх үндэстэй"¹⁵. Өөрөөр хэлбэл, давхар эгшгээр уртатгалыг тэмдэглэх нь монгол бичгийн зөв бичих зүйд бий болсон ойрмог цагийн үзэгдэл юм. Харин эртний монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд нэгэнт байсан зарим үгийн уртатгалыг давхар эгшгээр тэмдэглэдэг нь угтаа хоёр эгшгийн хоорондох гийгүүлэгчийн сугарлыг шууд тусган бичсэнээс үүдэлтэй зөв бичих зүйд хэвшин тогтсон хожмын хэлбэр болно.

¹² Qasbayan_a, *Mongyol törül kelen-ü abiyān-u qarīčayuluyṣan sudulul*, ÖMAKQ, 2001, 309-328.

¹³ Жишээ баримтыг Д.Төмөртоогоо "*Араб үсгийн монгол дурасхалын судалгаа*", *Удирдхал, үгсийн харьцуулсан толь, ном зүй* (Улаанбаатар, 2002) номоос авлаа.

¹⁴ Н.Н.Поппе, *Монгольский словарь Мукаддимат Ал-адаб*, I-II, Москва-Ленинград, 1938, стр. 17-19.

¹⁵ Д.Заяабаатар, *Монгол бичигт давхар эгшгээр уртатгалыг тэмдэглэдэг үгсийн тухайд*, МУИС, МССЭШБ:16 (160), Улаанбаатар, 2000, 113-120.

Тийм учраас, орчин цагийн монгол бичигт *buudai* ~~буудай~~ зэрэг бичлэгтэй үг нь сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалд *buγudai*, *buydai*¹⁶ гэсэн хэлбэрээр таарна. Уйгур, түрэгээр *buydai* гэнэ¹⁷. Мөн түрэг хэлэнд *toyla*¹⁸, *buyra*¹⁹ хэлбэртэй, монгол бичигт *tūula*, *buur_a* гэж бичдэг үгсийг энд хамруулж болно.

Гийгүүлэгчийн сугарлыг монгол бичгийн дурсгалд хэрхэн тусгасан талаар онцлон үзэхэд хос эгшгийн асуудал бас холбогдоно. Дундад үеийн монгол хэлэнд нэгэнтээ хэвшин тогтсон үгийн эцсийн буюу задгай үеийн хос эгшгийг XIII-XVI зууны монгол бичигт шууд тусган тэмдэглэсэн нь тодорхой билээ. Гэхдээ үүнийг зөвхөн дундад үеийн монгол хэлэнд хамаатуулаад зогсохгүй, одоо хүртэл мөрдсөөр буй монгол бичгийн зөв бичих зүйн ерөнхий тогтолцооны суурь болсон тэр цагийн хэл аялгууны онцлогийг тусгасан хэрэг гэж үзэлтэй. Доктор М.Базаррагчаа монгол бичигт үгийн эцсийн болоод эцсийн бус хос эгшгийг тэмдэглэсэн гэж үзээд, дэлгэрэнгүй эш баримтыг дурдахдаа "уйгуржин монгол бичгийг зохиох тэр үед "i"-ийн өмнө "y" гийгүүлэгч задгай үет үгэнд гээгдэж хэлэгдэх байсан ба үгийн эхэн ба дунд өргөлтөт эгшгийн ард гээгдэхгүй хэлэгдэж байсан байна"²⁰ гэжээ.

Бид үгийн эцсийн задгай үеийн хос эгшгийг монгол бичигт бүрэн тусган тэмдэглэснээс улбаалж, түүний хувьслын явцыг тодорхойлохдоо Н.Поппе, Ш.Лувсанвандан нарын үзсэнчлэн²¹, $V+y+i$ цогцоос үүссэн гэдэгтэй санал нэг байна. Өөрөөр хэлбэл, үгийн эцсийн хос эгшгийг Vy цогцоос үүссэн гэж тайлбарладаг нь эргэлзээтэй. Ерөөс, y гийгүүлэгч үе төгсгөж, дэвсгэрлэн ордоггүй бөгөөд энэ нь Чойжи-Одсэрийн "Зүрхний толтын тайлбар"-аас эхтэй монгол хэлний судлалд гүн хэвшлийг олсон ташаа үзэл байсан юм. Ташрамд тэмдэглэхэд, уламжлалт хэлшинжлэлийн сурвалж бичгүүдэд тодорхойлсон 11 дэвсгэр гийгүүлэгч, түүний дотроос w , y гийгүүлэгчийн тухай асуудлыг сайтар тодруулах шаардлагатай байна. Үүний талаар тусгай өгүүлэл бичих болно.

Үгийн эцсийн хос эгшгийн хөгжил хувьслыг хялбарчлан томъёолбол,

$$*V+g/y+i > *V+g/y+i > V+y+i > V\bar{i} > Vi$$

болно. Үүний бас нэгэн нуталгаа нь дөрвөлжин үсэгт үгийн эцсийн ai хос эгшгийг ayi цогцоор тэмдэглэдэг зүй тогтолт үзэгдэл юм.

Монгол хэлний авианы түүхэн хувьслын дотроос саналын зөрөөтэй байсаар байгаа судлагдахууны нэг нь үгийн эцсийн бус хос эгшгийн гарал үүсэл, улирал хөгжлийн тухай асуудал юм. Юун түрүүнд монгол бичгийн дурсгалд түүнийг хэрхэн тэмдэглэсэн тухай товч дурдъя.

Монгол бичгийн зөв бичих зүйд өнөөг хүртэл мөрдөгдсөөр буй эгшиг $+y+i$ цогцоор тэмдэглэх байдал нийтлэг боловч зарим талаар тэр цагийн хэл ярианд хэдийнээ бүрэлдэн тогтсон хос эгшгийн төлөвийг шууд тусгах хандлага гарч байжээ. Тухайлбал:

aimayud < **ayimayud*

[Maytayal:XII-2]

qairalan < **qayiralan*

[Čang:43]

naiman < **nayiman*

[Öljejitü:41], [Bčat:156b07], [Busayid:h18],

¹⁶ L.Ligeti, *Monuments préclassiques, XIII^e et XIV^e siècles*, MLMC II, Budapest, 1972, pp. 108-109, 236; F.W.Cleaves, *An early mongolian loan contract from Qara qoto*, HJAS:18, 1955, p.50; H.Franke, *Zwei mongolische textfragmente aus Zentralasien*, MS, 1970, p. 141.

¹⁷ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 120; Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKQ, 1987, 787-р тал.

¹⁸ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 571.

¹⁹ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 120; Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKQ, 1987, 782-р тал.

²⁰ М.Базаррагчаа, Ч.Жачин, *Уйгуржин монгол бичигт урт, хос эгшгийг тэмдэглэсэн нь*, "Монгол хэлний авианы чөлөөт сэлгэцийн тухай", Улаанбаатар, 1992, 113-р тал.

²¹ Nicholas Poppe, *Introduction to Mongolian comparative studies*, Second impression, Helsinki, 1987, p. 76; Ш.Лувсанвандан, *Уйгуржин монгол үсгийн дурсгалын зүйлийг галиглах тухай асуудал*, МС:2, Улаанбаатар, 1975, 34-р тал.

<i>naimdayu</i> < * <i>nayimdayu</i>	[Čong:02]
<i>nairay</i> < * <i>nayiray</i>	[Čang:30], [Burqan:59a]
<i>nirailatuyai</i> < * <i>nirayila-</i>	[Burqan:02a]
<i>uiyurčilan</i> < * <i>uiyurčilan</i>	[BodOS:17a08]
<i>uiyud</i> < * <i>uiyud</i>	[Indü:02]
<i>nairaldun</i> < * <i>nayiraldun</i>	[Indü:04; 11; 17; 20; 49]
<i>aisu</i> < * <i>ayisu</i>	[Qaraqorum1346:28]
<i>tein</i> < * <i>teyin</i>	[Sulqarnai:09b02, 09b07]
<i>qoina</i> < * <i>qoyina</i>	[Sulqarnai:10b12]
	[Sulqarnai:11b04, 12a07, 12b01, 12b05]

Эдгээр нь үгийн эцсийн бус хос эгшгийг тэмдэглэж байсны баримт мөн бөгөөд араб, хятад үсгийн зарим дурсгалд ч дундад үеийн монгол хэлэнд хэвшлээ олоод байсан энэхүү авианы хувьслыг тусгасан байдаг билээ. Гэвч үгийн эцсийн бус хос эгшгийг монгол бичгийн дурсгалд шууд тусган тэмдэглэсэн энэ мэт цөөн тохиолдлоор баримт болгож, уг авианы хувьслын хамаатах цаг хугацааг хэт урагшлуулан яривал учир дутагдалтай бөгөөд дундад үеийн монгол хэлний төлөв байдалд онолдуулах нь зүйд нийцнэ.

Монгол хэлний үгийн эцсийн бус хос эгшгийг монгол бичигт тэмдэглэх гол арга нь *Yi* цогц байдаг тухай өмнө дурдсан. Үүнээс үндэслэж, бидэнд уламжлан ирсэн баримт хэрэглэхүүний хүрээнд хашиж үзвэл, монгол бичгийн зөв бичих зүйн тогтолцоо суурилан буй болсон тэр цагийн хэл аялгуунд тэрхүү *Yi* цогц өнөөгийн хос эгшгийн байранд байжээ гэж хэлэх боломжтой. Харин уг цогц нь ямар хувьслаас эхтэй хийгээд цаашид хэрхэн улирч хувьссан бэ гэдэгт л монгол хэлний хос эгшгийн гарал үүслийг тайлбарлах учир зангилаа оршиж байгаа юм.

Хос эгшгийн гарал ирлийн талаар сонирхолтой томъёолол хийсэн эрдэмтэн бол Б.Я.Владимирцов мөн. Гэвч түүний үзсэнчлэн, $V+y(g)\sim w+V$ цогцын эхний эгшиг дээр өргөлт ноогдож байсан нь²² хос эгшиг үүсэх гол суурь болсон гэж хэлэхэд тун эргэлзээтэй. Ингэж үзвэл, урт эгшгийн гарал үүслийн асуудал ч ихээхэн будилаантай болоход хүрнэ. Тэгвэл хэрхэн тайлбарлах вэ?

Бидний санахад, "... орчин цагийн монгол хэлний үүсмэл урт эгшиг, үгийн эцэсийн бус үеийн хос эгшиг хоёр нь угтаа шүргэх $-y/g\sim y$ гийгүүлэгчийн хоёр талын эгшиг авиануудын нэгэн хувьслын хоёр өөр дүн"²³ гэдэгт эргэлзэх хэрэггүй юм. Эндээс, яагаад урт эгшиг бололгүй, хос эгшиг үүссэн юм бэ? гэсэн асуулт зүй ёсоор гарна.

Үүний учир зангилаа нь гагцхүү *i* эгшиг авианы хэв шинжтэй (*sound type or phonetic feature*) шууд холбоотой. Эгшгийн дотроос хамгийн уйтан шинжтэй нь *i* тул бусад авиаг татан ижилшүүлэх талаар сул, харин нөгөө авианы нөлөөнд автаж ижилшин хувьсах нь түгээмэл байдгийг олон баримт жишээгээр нуталж болно. Ялангуяа чанга, хэлний хойгуур хэлэгдэх эр эгшиг (*a, o, u*) авиа нь хэлний урдуурх, уйтан *i* урт эгшигт татагдаж, бүрэн ижилших авианы түүхэн хувьсал явагдахад ихээхэн хугацаа шаардаж таарна. Харин сул, хэлний дундуурх, уйтан эм эгшиг (*e, ö, ü*) авиа нь уйтан *i* урт эгшигт татагдаж, авианы шинжээрээ бүрэн ижилшихэд илүү дөхөмтэй юм.

Тэгэхээр, хос эгшгийн улиран хувьсч, хэвшин тогтсон үе шатыг дараах байдлаар тоймлон хэлж болмоор байна. Үүнд:

- ① Угаас утга ялгах өргөлттэй байсан *i* эгшиг нь хэлний түүхэн хөгжлийн явцад урт эгшгийн шинж төлөвийг олсон.
- ② Үүсмэл урт эгшгийн нөлөөгөөр өмнөх *g, y* гийгүүлэгч нь суларч, сул шүргэх *y* болсон.
- ③ Хоёр эгшгийн хоорондох сул шүргэх гийгүүлэгч сулран суларсаар аажимдаа сугаран

²² Б.Я.Владимирцов, *Сравнительная грамматика монгольского языка*, Москва, 1989, 279-281.

²³ Д.Төмөртоогоо, *Хос эгшигийн гарал хувьсал*, Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 103-р тал.

гээгдсэн.

- ④ Сул шүргэх гийгүүлэгчийн өмнө байсан богино эгшиг нь арын урт эгшигтэйгээ ухран ижилшсэн. Хэрэв богино эгшиг нь
- 4а. хүчдэлээр сул, уйтан *e* бол ухран ижилшиж, орчин цагийн монгол хэлний урт *i* эгшиг болсон.
- 4б. хүчдэлээр сул, уруулын *ü* бол арын урт эгшигтээ татагдан, бүрэн бус ижилшиж, *üi* хос эгшиг үүссэн. Зарим аялгуунд бүрэн ижилшиж, урт *i* болжээ.
- 4в. хүчдэлээр чанга, уужим *a*, уруулын *o*, *u* бол арын урт *i* эгшигийнхээ нөлөөгөөр тагнайшиж, орчин цагийн монгол хэлний *ai*, *oi*, *ui* хос эгшиг болжээ.

Хос эгшиг тус бүрээр жишээлэн үзүүлье.

PM **ayī* > **ayī* > AM **ayī* > **a'ī* > MM *aī* > *ai* > MoM *āi*
**ayīmay* > **ayīmay* > *ayīmay* > *a'īmay* > *aīmay* > (*aimay*) *āimay*

PM **oyī* > **oyī* > AM **oyī* > **o'ī* > MM *oī* > *oi* > MoM (*oi*) *ōi*
**oyīra* > **oyīra* > *oyīra* > *o'īra* > *oīrō* > (*oirō*) *ōirō*

PM **uyī* > **uyī* > AM **uyī* > **u'ī* > MM *uī* > *ui* > MoM (*ui*) *ūi*
**uyīla* > **uyīla* > *uyīla* > *uīla* > *uīlā* > (*uīlā*) *ūilā*

PM **ügi* > **ügi* > AM **ügi* > **ü'ī* > MM *üi* > MoM *üi* (~*i*)
**ügile* > **ügile* > *üyile* > *ü'ile* > *üilē*

PM **egi* > **egi* > AM **eyī* > **e'ī* > MM *eī* > MoM *ī*
**egimü* > **egimü* > *eyimü* > *e'īmü* > *eīmü* > *īmē*

Өмнө өгүүлсэн хос эгшигийн улирал хувьслын явцаас үүдэн хэлэхэд, орчин цагийн монгол хэлэнд *ei*-гийн хос эгшиг байдаг мэтээр зарим ном бүтээлд бичсэн ташаа ойлголтыг залруулах хэрэгтэй. Түүхэн хувьслын үүднээс үзвэл, *e+y+i* цогц байсан нь үнэн боловч орчин цагийн монгол хэлэнд энэхүү нийлэмжээс урт эгшиг (*i*) үүссэн нь гарцаагүй билээ. Уг ташаарал нь шинэ үсгийн зөв бичих зүйд “эй”-гийн хос эгшигийг тэмдэглэснээс улбаатай биз ээ.

Нөгөө талаар хос эгшигийн хувьсал хөгжлийн тухай ярихад, монгол хэлний эрт үед *öyi* цогц байсан уу? гэх асуулт зайлшгүй гарах ёстой. Байгаагүй гэж хэлэх ноцтой шалтгаан байхгүй. Нэрт монголч Н.Поппе “*öyi* цогц нь монгол хэлнүүдэд нэлээд эрт цагт *üyi*-тэй нэгдэн нийлсэн байна”²⁴ гээд *süike* < **söyike*, *küiten* < **köiten* < **köyiten* зэргээр жишээлсэн байдгийг бас анхаарууштай юм. Үүнийг ортой дүгнэлт гэж бодож байна. Дэлгэрүүлэн тайлбарлавал, эм сул, уйтан *ö* арынхаа *i* эгшигт ухран ижилшиж, уйтаншихын зэрэгцээ хэлэх сонстохын талаас улам суларч, аажимдаа *ü* эгшигийн шинж төлөвт шилжсэнээс үүдэлтэй болов уу. *Küiten* гэдэг үгийн *kö-* язгуур *körkü*, *köldekü* зэргээр одоо ч байна.

Энд онцлон дурдууштай нэгэн зүйл бол, үгийн эцсийн бус *üi* хос эгшигийг монгол бичигт хэрхэн тэмдэглэсэн тухай асуудал юм. Олны мэдэхээр, орчин цагийн монгол бичигт ~~ᠡᠢ~~ гэхчилэн бичдэг. Монгол бичгийн дурсгалд ч мөн адил байна. Ийм үгсийг монгол бичгийн галигт *üyi*, *üi* гэх мэтээр зөрөөтэй буулгадаг. Уг бичлэгийн онцлогийг зурлага хэмнэх гэсэн оролдлого, эсэхүл “~~ᠡᠢ~~” гэж нэг тэмдэгтийг гурван удаа давхардуулан бичихээс зайлсхийсэн”²⁵ хэрэг гэж тайлбарлаад орхих нь эргэлзээтэй л болов уу. Бидний санахад, үгийн эцсийн бус *üi* хос эгшигийг монгол бичигт тусган тэмдэглэсэн цагаас эх үүдэлтэй болов уу.

Мөн *naiman* ~~ᠨᠠᠶᠢᠮᠠᠨ~~ гэх өвөрмөц бичлэгтэй үгэндэх нэг шилбийг (йод Д.3) Данзан, Шонхор нарын эрдэмтэн у дэвсгэр хэмээн тодорхойлсон²⁶ бөгөөд бид монгол бичигт хос эгшигийг тусган тэмдэглэх гэсэн оролдлогоос зөв бичих зүйд хэвшин тогтсон хэлбэр гэж бодож байна.

²⁴ Nicholas Poppe, *Introduction to Mongolian comparative studies*, Second impression, Helsinki, 1987, pp. 81-82.

²⁵ Б.Я.Владимирцов, *Сравнительная грамматика монгольского языка*, Москва, 1989, стр. 273.

²⁶ Danzan, “~~ᠡᠢ~~” *gedeg onᠰayai bicilge-yin ucir*, Монгол үсэгзүйн асуудлууд, ÖMSKKQ, 2001, 124-128;

Энэ бүхнээс үүдэн дүгнэхэд, орчин цагийн монгол хэлэнд хос эгшиг авиа бүрэлдэн тогтсоны чухам учир нь $*V+g/\gamma+i > *V+g/\gamma+i > V+\gamma+i > V\bar{i}$ хувьслас улйрсан $V\bar{i}$ нийлэмжийн уйтан i эгшиг өмнөх эр чанга, уужим a ; эр чанга, уруулын o , u ; эм сул, уруулын i эгшигийг бүрэн ижилшүүлж чадаагүй буюу угтаа урт эгшиг болоогүйд л оршиж байна. Өөрөөр хэлбэл, монгол хэлний үүсмэл урт эгшигийн түүхэн хөгжлийн явцад хэвшин тогтсон авианы онцгой нэгэн хувьсал нь даруй хос эгшиг болно.

Ямар ч атугай, хос эгшигийн бүрэлдэн тогтох явц, цаг хугацаа, дамжин туулсан авианы хувьслыг тодруулахад монгол бичгийн зөв бичих зүйг онцгой анхаарч, тэр дундаа эрт үеийн дурсгал дахь бичлэгийн хэлбэрт анхаарлаа хандуулах нь нэн чухал байна.

2. Гийгүүлэгчийн сулрал

Монгол бичигт, урт эгшигийг эгшиг+γ+эгшиг гэсэн нийлэмжээр тэмдэглэдэг гол зарчимтай бөгөөд түүнээс гадна i+γ+эгшиг нийлэмжээр тэмдэглэх, мөн богиноор бичиж уртаар дуудах тохиолдол бий. Үүсмэл урт эгшигийн хөгжил хувьслын үүднээс хандвал, өнөөгийн монгол бичигт *ariyatan*, *iniye-*, *kičiye-*, *emiye-*, *quriya-*, *jöbsiye-*, *üniy_e* гэж бичдэг бүлэг үгийн өмнөх хэлбэрийг доорх мэтээр сэргээн гаргаж болно.

**ariyātan > ariyātan*
**quriyā- > quriyā-*
**emigē- > emiyē-*
**jöbsigē- > jöbsiyē-*
**tariyān > tariyān*

**inigē- > iniyē-*
**kičigē- > kičiye-*
**sayisiyā- > sayisiyā-*
**ünigēn > üniyēn*
**taqiyu > takiy_a*

Тэгвэл тэрхүү эртний хэлбэрийг тусган бичсэн бодот баримтыг сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалаас төвөггүй олж болох юм.

ariyatan
kičigen uruysi jigdün yabuyad
kičigel qatayujil
kičigen qatayujiyad
kičigen yabuyči

[Subasida VI-13a; VIII-18a]
 [Indü:29]
 [Indü:45]
 [Čang:51], [Čang:19]
 [Čang:51; 54], [Jigüntei:21],
 [Takimdayu:07b05]
 [Qaraqorum:17], [Turfan/Aduyu:14]
 [Qubilai1261:38]
 [Jigüntei:05]
 [Uwayis:12]
 [Subasida:I-8a]
 [Subasida:II-3a], [Busayid:g3]

ulus quriyaysan
jarliy manu taqiyu jil
sayisiyan maytaydaju
silyan soyubasu jobsigejü
ünigen-eče sün-i ken ber abu čidamui
yajar taqi tariyan-i ülemji öskeyü

Академич Д.Төмөртогоо "Дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн хооронд байсан шүргэх γ/g -гийн арын урт эгшиг нь өмөнөх гийгүүлэгчээ суларуулах нөлөөтэй байсан бол түүний өмөнө талын богино i (их төлөв тагнайшсан гийгүүлэгчийн дараа орсон Д.Т) эгшиг нь түүнийг тагнайшуулах төлөвтэй байжээ"²⁷ хэмээн тэмдэглээд уг хувьслыг "...монгол хэлний урт удаан түүхэн хөгжилийн маш богино зурвасхан үеийг хамарсан түр зуурын үзэгдэл" гэж үзсэнийг дурдах нь зүйтэй. Тэгвэл, тэр зурвасхан үеийг тусгасан бичлэгээс монгол бичгийн зөв бичих зүйд хэвшин тогтсон хэлбэрүүд цөөнгүй байгааг дээрх жишээ баримт тов тодорхой харуулж байна.

Šongqur, *Erten-ü mongγol kelen-ü sudulul*, ÖMSKKQ, 1996, 554-р тал.

²⁷ Д.Төмөртогоо, *Дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн хоорондох гийгүүлэгчийн суларал*, Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 139-140.

Орчин цагийн монгол бичгийн зөв бичих зүйд урт эгшгийг тэмдэглэх нэгэн арга нь “*i+y+эгшиг*” гэсэн цогц байдаг тухай өмнө дурдсан. Харин *belčige-*, *tejige-* гэх мэт цөөн үгэнд дурдан буй цогцын эртний хэлбэр нь хадгалагдан үлдсэн билээ. Монгол бичгийн дурсгалын зүйлд ийм үгсийг хэрхэн бичсэнийг ажиглахад, *g* гийгүүлэгчтэй хийгээд *g* гийгүүлэгч суларч *y* болсон хэлбэрийн аль алийг хадгалсан жишээ нэг үгийн үндсэнд тохиолдож байгаа нь их сонирхолтой байна.

<i>ečige ekes-i tejivyegsen ači qariyulun kemen</i>	[Aryu:12]
<i>aman qoyulai tejigen qatayujiyad</i>	[Indü:27]
<i>ečige eke-de törügüldegsen ba tejivyegdegsen</i>	[Indü:02]
<i>emigejü qayiralaju</i>	[Takimdayu:02a06]
<i>emiyeged asaybasu</i>	[Takimdayu:29a05]

Цааш нь *quriya-*, *quriya-*; *emige-*, *emiye-*; *kičige-*, *kičiye-*; *inige-*, *iniye-*; *kejige*, *kejiy_e* гэх мэтээр цөөнгүй үгийг дурдаж болно.

Ер нь утга ялгах өргөлтөөс үүсэлтэй урт эгшгийн өмнөх гийгүүлэгч сулран сугарах хувьсал нь **b>*y/g>h/w/y>Ø* шатыг туулжээ. Тэгвэл, монгол бичгээр *debel*, *ibegen* (*-ibegel*) гэж бичдэг үгсийн дараагийн хувьсал нь даруй *degel*, *igegen* байх ёстой. Сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалд “дээл” гэсэн үгийг ‘*b*’ гийгүүлэгч суларч, *-g-* болсон хэлбэрээр *degel* [Jigüntei:18], [Burqan:25b, 27a, 43a], [Subasida:VII-2a]; “ивээл” хэмээх үгийг “*-b-*”, “*-g-*”-тэй хэлбэрийн аль алиныг тусгаж, *ibegel* [Indü:03], *ibegen* [BčaT:165b05], [Qubilai1268:02], *igegen* [Ösbeg:a2], [Abdulla:a2] гэх зэргээр тэмдэглэсэн байна.

Үүнийг зүгээр алдаа мадаг гэж хэлээд орхиж болохгүй. Тус онцлог нь бичгийн хэл болоод аман ярианы хоорондын нөлөө тусгал, урт эгшгийн хувьсал хөгжлийн тухай асуудалд холбогдох үнэ цэнтэй баримт мөн гэдэгт итгэлтэй байна. Энэ мэт тохиол нь зөвхөн сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалаар хязгаарлаад зогсохгүй өнөөгийн монгол бичгийн зөв бичих зүйд ч монгол хэл аялгуу болоод бичгийн хэлний хөгжлийн түүхийг нарийвчлан судлах, монгол хэлшинжлэлд бүдэг бүрхэг байсаар буй зарим асуудлын учир зангилааг тайлж, маргаантай санал дүгнэлтийн ац хагалах баримт нуталгаа нуугдсаар буйн тод илрэл юм.

Ташрамд дурдахад, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь “Дуутын хар чулуу” (=Дуутын хад) хэмээх өвөрмөц сонин тогтоцтой газарт орших гурван зүйл бичээсийн бага бичээст “*Dayičing kiyagiin (kiy_a-yin Д.З) degü (degüü) Amur kiy_a bičibei*”²⁸ хэмээн, эгшгийн дундах жийрэг гийгүүлэгчийг шууд тусган тэмдэглэсэн нь тэр цагийн ярианы хэлний онцлогийг илтгэх сонин баримт болдог юм.

Өмнө жишээлсэн бүлэг үгсийн уртатгалыг тэмдэглэх *i+y+эгшиг* нийлэмж нь дундад үеийн монгол хэлний угтал үе буюу эртний монгол хэлнээс дундад үеийн монгол хэлэнд шилжих зааг үед гарсан авианы хувьслыг бичгийн хэлэнд тусган буулгаснаас эхтэй бөгөөд улмаар монгол бичгийн зөв бичих зүйд урт эгшгийг тэмдэглэх нэгэн арга болон хэвшжээ.

Тэгэхээр, монгол бичгийн зөв бичих зүйд урт, хос эгшгийг тэмдэглэх хэдэн зүйл арга нь тус бүртээ хэлний хөгжилд гарсан хувьсал өөрчлөлтийг шууд тусган тэмдэглэснээс эх үүдэлтэй зүй тогтол юм. Үүнээс үзвэл, монгол бичиг нь анх тулгар буй болсон үеийнхээ мөрдлөг журам, зүй тогтлыг бат нягт хадгалахын зэрэгцээ хэлний түүхэн хөгжлийн явцад гарсан зарим нэгэн хувьсал өөрчлөлтийг зохих хэмжээгээр тусгаж, улмаар тэрхүү шинэ тугдам нөлөө тусгал нь зөв бичих зүйн тогтолцоонд тусгай арга зарчим болтлоо хэвшин тогтжээ гэдгийг дүгнэн хэлэх боломжтой байна.

²⁸ Д.Заяабаатар, “Дуутын хар чулуу”-ны монгол бичээсийн хэлний онцлог, АМ:1 (182), Улаанбаатар, 2002, 107-116.

3. Эгшгийн ижилшил

Дундад үеийн монгол хэлний үед эгшиг авиа аль хүчтэй эгшигтээ татагдах байдлаараа ижилшин хувьсаж байсныг дөрвөлжин, хятад, араб үсгийн дурсгалаас тодорхой харж болно. Харин монгол бичгийн дурсгалд энэхүү авианы хувьслыг нэгэн мөр тогтолцоотой тусгасангүй. Гэвч цөөн боловч баримт тохиолдож буйгаас жишээлэн үзүүлбэл:

<i>öbül</i> < * <i>ebül</i>	[Möngke1254:14], [Jebetemür:21], [Sulqarnai:12a11], [Abaya13], [Aryun:14], [Subasid:III6a]
<i>ödür</i> < * <i>ediür</i>	[Čang:17], [Indü:52], [Takimdayu18a05; 26a07], [Jigünte:09], [Gasan:15];
<i>buyuysan</i> < * <i>bayuysan</i>	[Jigünte:10]
<i>jobolang</i> < * <i>jobalang</i>	[BčaT:162b03; 164b03; 165a03]
<i>jobon</i> < * <i>joban</i>	[BčaT:158a06]
<i>olon</i> < * <i>olan</i>	[Burqan:14a]
<i>jögölen</i> < * <i>jögelen</i>	[Subasida:VIII-7b]
<i>oytoryui</i> < * <i>oytaryui</i>	[BčaT:156b09; 157b09; 163b12; 164a12]
<i>oytol-</i> < * <i>oytal-</i>	[Subasida:II-6b; IV-8a; VI-3b]
<i>oryon</i> < * <i>oryan</i>	[Takimdayu:05b04; 12a01; 12a04]
<i>qotod</i> < * <i>qotad</i>	[Indü:21]

Ер нь дундад үеийн монгол хэлэнд уруулын эгшиг авиа тэргүүн болон тэргүүн бус үед орсон эгшиг авиагаа татан ижилшүүлэх хувьсал хамгийн хүчтэй байжээ. Тийм ч учраас, монгол бичгийн дурсгалд эгшгийн ижилшлийг тусган тэмдэглэсэн тохиолдол гол төлөв уруулаар ижилших хувьсалд хамаатаж байгаа хэрэг.

Нөгөөтээгүүр, энд зайлшгүй дурдах ёстой нэг онцлог бол монгол бичгийн дурсгалд эгшгийн ижилшлийг тусгахаас гадна зарим үгийн хүчдэлээр зохицож байсан эрт үеийн хэлбэрийг улируулан тээж ирсэн явдал мөн.

Ер нь өнөөгийн монгол бичгийн зөв бичих зүйд хүчдэлийн талаар зохицож байсан эрт үеийн онцлогийг улируулан уламжлахын хамт хэлний түүхэн хөгжлийн явц дахь авианы ижилшлийг тусган тэмдэглэсэн байдал нь хэвшил болон тогтсон тохиол цөөнгүй бий. Жишээлбэл: *түрэг*, *төр*, *төрөл*, *төрөл* гэх мэт бичлэгийн хэлбэр нь эгшиг авиа чанга хөндийгөөр зохицож байсны ул мөрийг хадгалж байгаа бол *түрэг*, *төрөг*, *төрөг*, *төрөг* гэх зэрэг үгийн бичлэг нь уруулаар ижилших хувьслыг шууд тусгаснаас үүдэлтэй байна. Авианы хувьслыг загварчилбал, **oran* > *oron*, **töre-* > *törö-*, *oro* > **orai*, *oro-* > **ora-* болно. Ийм үгсийг монгол бичгийн дурсгалд тэмдэглэхдээ, уруулын ижилшлийг тусган бичихийн зэрэгцээ хүчдэлээр зохицож байсан эртний хэлбэрийг хадгалсан газар олон байдаг.

* <i>oran</i> > MS <i>orun</i>	[Čang:18], [TurfanTQ:18]
* <i>orai</i> > MS <i>orui</i>	[Sulqarnai:12b10], [Subasida:II-4b]
* <i>töre-</i> > MS <i>törü-</i>	[Sulqarnai:13b02], [Turfan/Kümün:01, 02, 13]
* <i>törel</i> > MS <i>törül</i>	[Turfan/Kümün:02]
* <i>osal</i> > MS <i>osul</i>	[Burqan:63a]
* <i>ongyačacin</i> > MS <i>ongyuča</i>	[Abaya:06]
* <i>adayun</i> > MS <i>aduyun</i>	[Subasida:IV-8a]
* <i>ora-</i> > MS <i>oru</i>	[Uwayis:11, 26], [Indü:29], [Sulqarnai:13a12]

Үүний бас нэгэн нуталгаа нь "Монголын Нууц Товчоон", "Hua-yi Yi-yü", араб үсгийн дурсгалд тэдгээр үгийг дийлэнхдээ *oran*, *töre-* хэлбэрээр тэмдэглэсэн явдал юм. Уйгур, түрэг хэлэнд *töre-*, *oraj*, *osal*, *ada*, *ora* гэх мэтээр дэд үеийн уруулын эгшгийн байранд *a*, *e* эгшгүүд тохиолдох ажээ²⁹.

²⁹ Sečenöyту, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKQ, 1987, 85, 357, 373, 1983-р талууд.

Сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалд авианы түүхэн хувьслыг тусгасан байдлаас улируулан дүгнэхэд, монгол бичгийн зөв бичих зүй нь анх олсон хэвшинжээ тогтвортой хадгалахын сацуу туулж өнгөрсөн цаг үеийнхээ авианы хувьсал, хэлзүйн шинэ тугдам зүй тогтлыг тодорхой хэмжээгээр тусгасаар иржээ. Иймээс, хэлний түүхэн хөгжлийн явцад гарсан аливаа хувьсал өөрчлөлт нь монгол бичгийн зөв бичих зүйд тодорхой хэмжээгээр ул мөрөө үлдээж байв.

Өөрөөр хэлбэл, монголчуудын хэрэглэж ирсэн хэдэн зүйлийн үсэг бичгийн тогтолцооны дотроос хамгийн урт хугацааг туулж ирсэн монгол бичиг нь түүхэн хөгжлийн явцдаа хэзээ ч зогсонги байсангүй ярианы хэлэнд гарсан төрөл бүрийн хувьсал өөрчлөлтийг тусган тэмдэглэсээр иржээ. Тийм учраас, монгол бичгээр уламжлан ирсэн сурвалж баримтууд нь монгол хэлний түүхэн хөгжлийн гурван шат үеийн (эртний монгол хэл, дундад үеийн монгол хэл, орчин цагийн монгол хэл) төлөв байдлыг улируулан шинжлэхэд үнэ цэнтэй хэрэглэхүүн болно.

Ингэж үзвэл, сонгодог бичгийн өмнөх үе буюу XIII-XVI зуунд хамаатах монгол бичгийн дурсгалаас эртний монгол хэлний төлөв байдлын зарим хэсгийг нэхэн тодруулахын зэрэгцээ дундад үеийн монгол хэлэнд гарсан авиа, хэлзүйн түүхэн хувьслын тусгал нөлөөг зохих хэмжээгээр тэнхрүүлэн сэргээх боломжтой юм.

Жишээ татсан дурсгалын нэрийн товчлол

[Möngke1254]	Мөнх хааны зарлигийн бичээс (1254)
[Qubilai1261]	Хубилай хааны зарлигийн бичээс (1261)
[Qubilai1268]	Хубилай хааны зарлигийн бичээс (1268)
[Abaya]	Абага хааны захидал (1267 / 1279)
[Jebetemür]	Зэвтөмөр вангийн зарлигийн бичээс (1277)
[Aryun1289]	Аргун хаанаас Гоо Филиппт илгээсэн захидал (1289)
[Gasan]	Гасан хаанаас VIII Бонифаст илгээсэн бичиг (1302)
[Öljeiyitü]	Өлзийт султанаас Гоо Филиппт илгээсэн захидал (1305)
[BçaT]	Бодичариявадарагийн тайлбар (1312)
[Indü]	Индү вангийн гэрэлт хөшөөний бичээс (1335)
[Jigüntei]	Жигүнтэйн гэрэлт хөшөөний бичээс (1338)
[Aруу]	Аруг вангийн гэрэлт хөшөөний бичээс (1340)
[Qaraqorum1346]	Хархорумын I бичээс (1346)
[Çong]	Чон вэйн гэрэлт хөшөөний бичээс (1348)
[Çang]	Чан Йин-жүйн гэрэлт хөшөөний бичээс (1362)
[Sulqarnai]	Сулхарнайн тууж
[Uwayis]	Увайс баатар ханы зарлиг
[Busayid]	Бусайд баатар ханы зарлиг
[Turfan/Tamu]	Там биридийн тухай шүлэг, Турфаны цуглуулга
[Turfan/Aduyu]	Адуун сүргийн тооллогын тухай илтгэмж
[Turfan/Kümün]	Хүнлэг сайн явдлыг сургасан шүлэг, Турфаны цуглуулга
[Nur Ad-din]	Нур Ад-диний бичиг
[Maytayal]	Дарь эхийн магтаал
[Dara/Tegüsge]	Дарь эхийн магтаалын төгсгөл үг
[Ösbeg]	Өзбег-ийн пайз
[Abdulla]	Абдулла-гийн пайз
[Qara qotaII]	Хар хотоос олдсон барын номын тасархай
[Takimdayu]	Тахимдуу ном буюу Ачлалт ном
[Burqan]	Бурханы арван хоёр зохионгуй